



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 367

Улаанбаатар хот

**Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах  
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий Прокурорын газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 52,341,000.00 (тавин хоёр сая гурван зуун дөчин нэгэн мянга) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, харьяа Прокурорын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

130004809  
18-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн  
 30 дугаар тогтоолын хавсралт



УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ХАРЬЯА ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН  
 ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ  
 АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 469 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
Нийслэлийн Баянгол дүүргийн прокурорын газар					
1	Ниссан сани, улсын дугаар 04-55 УНУ, арлын дугаар MDHRBBAN17Z0002455	2012/2015	27,000,000.00	3,000,000.00	1,500,000.00
Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын прокурорын газар					
2	Санта Фи, улсын дугаар 73-13 СЭҮ, арлын дугаар KMHSN81XCBU695827	2010/2010	25,341,000.00	3,000,000.00	1,500,000.00
			52,341,000.00	6,000,000.00	3,000,000.00
Нийт дүн			(тавин хоёр сая гурван зуун дөчин нэгэн мянга)	(зургаан сая)	(гурван сая)